Улсын бvртгэлийн еронхий газрын эрхэм зорилго нь улсын бvртгэлийн vйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжvvлэхэд оршино.

## Стратегийн зорилт

**Үйл ажиллагааны стратегийн зорилт**
2.4.1. улсын бvртгэлийн vйл ажиллагааны эрх зvйн орчныг боловсронгуй болгож, улсын бvртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжvvлнэ.
2.4.2. улсын бvртгэлийн нэгдсэн тогтолцоог бvрдvvлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хоронгийн эрхийн улсын бvртгэлийн vйлчилгээг тvргэн шуурхай, чанартай vзvvлнэ.
2.4.3. улсын бvртгэлийн vйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног тохооромж, программ хангамжийг сайжруулна.
2.4.4. улсын бvртгэл болон улсын бvртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.
2.4.5. улсын бvртгэлийн байгууллагын vйл ажиллагаанд хяналт шинжилгээ, vнэлгээ, дотоод аудит тогтмол хийж, vр дvнг сайжруулна.
2.4.6. иргэний, хуулийн этгээдийн, эд хоронгийн эрхийн улсын бvртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хомрог бvрдvvлж, баяжилт хийж, тvvний хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.
2.4.7. гадаад хамтын ажиллагааг оргожvvлж, улсын бvртгэлийн vйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бvртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.
2.4.8. улсын бvртгэлийн байгууллагын удирдпагын менежмент, хvний нооцийн толовлолтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хvчний чадавхыг дээшлvvлнэ.
2.4.9. санхvv, тосвийн удирдлага болон тосвийн гvйцэтгэлийн хяналтыг хэрэгжvvлнэ.

## Тэргvvлэх чиглэл

**Улсын бvртгэлийн ерөнхий газар дараах vйл ажиллагааны тэргvvлэх чиглэлтэй байна:**
2.2.1. улсын бvртгэлийн нэгдсэн тогтолцоог бvрдvvлэн бэхжvvлэх, мэдээллийг хэрэглээнд оруулах дундын огогдлийн системийг бий болгон хогжvvлэх;
2.2.2. улсын бvртгэлийн vйл ажиллагаанд орчин vеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрvvлэх замаар vйлчилгээний хvртээмж, шуурхай байдлыг сайжруулах;
2.2.3.улсын бvртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгvй байдлыг хангах.